

Үйлчилгээний нөхцөлүүд

Энэхүү нөхцөлүүд нь нэг талаас суралцагч буюу эсвэл сургагч та, нөгөө талаас **Softuni.mn**-ын хооронд хүчин төгөлдөр гэрээ болж үйлчлэх ба таны хууль ёсны эрх, нөхөн төлбөр, үүргийн талаарх чухал мэдээллийг агуулсан тул анхааралтай танилцана уу.

Softuni.mn-ийн эрхэм зорилго нь суралцагсдад хэзээ ч, хаанаас ч мэдээллийн технологийн сургалтын контентуудад хандах боломж олгох явдал юм.

Энэхүү нөхцөлүүд нь **Softuni.mn** цахим хуудас дахь үйлчилгээнүүд дэх таны бүх үйл ажиллагаанд хамаарна.

Бүртгэл

Та манай платформд үйлдэл хийхийн тулд бүртгэлтэй байх ёстой. Та өөрийн бүртгэлтэй холбоотой бүх үйл ажиллагааг хариуцах тул нууц үгээ аюулгүй хадгалаарай. Хэрэв та хэн нэгэн таны бүртгэлийг ашиглаж байна гэж сэжиглэж байгаа бол бидэнд мэдэгдээрэй.

Та манай платформд үйлдэл хийх, тухайлбал сургалт худалдаж авах, хандах, шалгалт өгөх, эх сурвалжуудыг татах, уншихын тулд бүртгэлтэй байх шаардлагатай. Бүртгэлээ тохируулах, хөглөхдөө та хүчинтэй имэйл хаяг зэрэг үнэн зөв, бүрэн мэдээллийг өгөх ёстой. Та өөрийн бүртгэлдээ тохиолдсон бүх зүйлд, тэр дундаа хэн нэгэн таны бүртгэлийг зөвшөөрөлгүйгээр ашигласнаас үүдэн учирсан аливаа хохирлыг өөрөө бүрэн хариуцна. Энэ нь та нууц үгээ болгоомжтой ашиглах хэрэгтэй гэсэн үг юм. Та бүртгэлээ хэн нэгэнд шилжүүлэх эсвэл хэн нэгний бүртгэлийг ашиглах боломжгүй. Хэрэглэгч нас барсан тохиолдолд тухайн хэрэглэгчийн бүртгэл хаагдана.

Та өөрийн бүртгэлд нэвтрэх эрхээ хэн нэгэнтэй хуваалцаж болохгүй. Та өөрийн бүртгэлтэй холбоотой бүхнийг хариуцах ёстой ба **Softuni.mn** нь бүртгэлд нэвтрэх эрхээ хуваалцсан суралцагчдын хооронд гарсан маргаанд оролцохгүй. Хэн нэгэн таны бүртгэлийг зөвшөөрөлгүйгээр ашиглаж байгааг мэдсэн даруйдаа манайд мэдэгдэх ёстой. Таныг үнэхээр тухайн бүртгэлийг эзэмшигч мөн гэдгийг батлахын тулд бид танаас зарим мэдээллийг хүсч болно.

Суралцагчид ба сургагч нар **Softuni.mn**-д бүртгэл үүсгэж, үйлчилгээг ашиглахын тулд **16** нас хүрсэн байх ёстой. Хэрэв та **16**-аас доош настай, хуулиар онлайн үйлчилгээ ашиглах зөвшөөрөл авах шаардлагатай бол эцэг эхийнхээ туслалцаа авна. Хэрэв та энэхүү шаардлагыг зөрчиж бүртгэл үүсгэсэн бол бид таны бүртгэлийг цуцлана.

Сургалтын худалдан авалт ба хандах эрхийн хугацаа

Та аль нэг сургалтад бүртгүүлэхдээ **Softuni.mn**-ээр дамжуулан түүнийг үзэх эрх авах ба түүнийг өөрөөр ашиглах эрхгүй. Сургалтын контентыг бусдад дамжуулах юмуу цааш зарах ёсгүй. Бид танд тодорхой зөвшөөрөл өгөөгүй бол та аливаа контентыг хуулбарлах, цааш түгээх, бусдад дамжуулах, худалдах, стрийм хийх, түрээслэх, хуваалцах, зээлдүүлэх, өөрчлөх, засварлах, үүсмэл бүтээл үүсгэх, бусад хэлбэрээр шилжүүлэх, ашиглахыг хориглоно.

Softuni.mn дэх сургалтынхаа үнийг бид өөрсдийн үнийн бодлогоор тогтоодог. Бид зарим тохиолдолд сургалтын контентуудынхаа зэрэгцээ сурталчилгаа, борлуулалт хийх ба энэ хугацаанд тодорхой контентыг тодорхой хугацаанд хөнгөлөлттэй үнээр авах боломжтой.

Та худалдан авсан сургалтын контентынхоо төлбөрийг төлөхийг зөвшөөрч, эдгээр хураамжийг дебит эсвэл кредит картаасаа авах, эсвэл бусад төлбөрийн хэрэгслээр боловсруулахыг зөвшөөрөх боломжтой. **Softuni.mn** төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудтай хамтран ажиллаж, төлбөрийн хамгийн тохиромжтой аргыг санал болгож, төлбөрийн мэдээллийг тань аюулгүй байлгана. Бид төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчдийнхээ өгсөн мэдээллийг ашиглан таны төлбөрийн хэрэгслийг системдээ шинэчлэнэ.

Та худалдан авалт хийхдээ хүчингүй эсвэл зөвшөөрөлгүй төлбөрийн аргыг ашиглахгүй байх ёстой. Хэрэв таны төлбөрийн хэрэгсэл бүтэлгүйтсэн ч бүртгүүлсэн контентдоо хандах эрхтэй хэвээр байвал биднээс мэдэгдэл ирснээс хойш **30** хоногийн дотор холбогдох төлбөрийг төлөх ёстой. Бид зохих төлбөрөө төлөөгүй аливаа контентод хандах эрхийг тань хаах эрхтэй.

Сургалтын контент ба зан үйлийн дүрэм

Та **Softuni.mn**-г зөвхөн хууль ёсны зорилгоор ашиглах ёстой. Та өөрийн бичсэн шүүмж, асуулт, нийтлэл, хичээл, сургалт ба бусад контентоо хууль тогтоомжид нийцүүлж, бусдын оюуны өмчийн эрхийг хүндэтгэх ёстой. Давтан эсвэл томоохон зөрчил гаргасан тохиолдолд бид таны бүртгэлийг хаана.

Манай платформын үйлчилгээг ашиглах таны зан үйл Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, дүрэм журмуудад нийцсэн байх ёстой. Та өөрт хамаарах эдгээр хууль тогтоомжийг мэдэж, дагаж мөрдөөрэй.

Хэрэв та суралцагч бол элссэн сургалт юмуу бусад контентыг нийлүүлсэн сургагч нараас асуулт асуух, мөн контентын талаар сэтгэгдлээ нийтлэх эрхтэй.

Хэрэв та сургагч бол платформд өөрийн хичээл юмуу бусад контентод бүртгүүлсэн суралцагчидтай харилцах боломжтой. Аль ч тохиолдолд та хуулийг дагаж, бусдын эрхийг хүндэтгэх ёстой.

Хэрэв та төлбөрөө төлөх хугацаандаа төлөөгүй бол бид манай платформ болон сургалтын үйлчилгээг ашиглах зөвшөөрлийг тань ямар ч үед хязгаарлаж, цуцалж, эсвэл таны бүртгэлийг устгаж болно. Хууль сахиулах байгууллага эсвэл төрийн байгууллагуудын хүсэлтээр, удаан хугацаагаар идэвхгүй байсан, техникийн гэнэтийн асуудал, залилан мэхлэх, хууль бус үйл ажиллагаа явуулж байна гэж сэжиглэж байгаа бол, эсвэл өөрсдийн үзэмжээр таны үйлчилгээг цуцалсны дараа бид таны бүртгэл болон контентыг устгаж болох ба манай платформ руу нэвтрэх, манай үйлчилгээг ашиглахыг хориглох боломжтой. Таны бүртгэлийг цуцлах, сургалтын контентыг устгах, манай платформ, үйлчилгээнд нэвтрэх эрхийг хаасан тохиолдолд бид таны болон гуравдагч этгээдийн өмнө хариуцлага хүлээхгүй гэдгийг та үүгээр хүлээн зөвшөөрч буй юм.

Softuni.mn-ийн эрх

Бид **Softuni.mn** платформ, түүний код, ажилтнуудын маань бүтээсэн сургалтын контент зэрэг зүйлүүдийг эзэмшдэг. Та тэдгээрт хөндлөнгөөс оролцох эсвэл зөвшөөрөлгүйгээр ашиглах ёсгүй. Манай платформ ба үйлчилгээнүүд нь зохиогчийн эрх, барааны тэмдэг ба Монгол Улсын хуулиудаар хамгаалагдсан.

Та **Softuni.mn** платформ ба үйлчилгээнд хандах, ашиглах явцдаа дараах зүйлүүдийг хийж болохгүй. Үүнд:

- Платформын мэдээллийн аюулгүй байдалтай холбоотой аль нэг онцлогийг идэвхгүй болгох, хакердах, хууль бусаар нэвтрэх эсвэл манай системийн аль нэг эмзэг талыг шалгах, сорих.
- **Softuni.mn** платформын аливаа эх код эсвэл сургалтын контентыг хуулах, өөрчлөх, үүсмэл бүтээл үүсгэх, урвуу инженерчлэл хийх, урвуу угсрах, эсвэл өөр аргаар олохыг оролдох.
- Манай цахим хуудас, хэрэглүүр, API-аар өгөгдсөн одоогийн хайлтын функцүүдээс бусад аргаар манай платформд хандах, хайлт хийх.
- Вирус илгээх, платформыг хэт ачаалах, спам илгээх, цахим шуудангаар “бөмбөгдөх” зэргээр худал мэдээллээр халдлага үйлдэх.

Сургалтын үйлчилгээг худалдан авах нөхцөл

Та манай сургалтын үйлчилгээг худалдан авсанаар биднээс тухайн сургалтын үйлчилгээний төлөвлөгөөнд багтсан контентыг үзэх хязгаарлагдмал, онцгой бус, шилжүүлэх боломжгүй эрх авна.

Таны худалдаж авсан эсвэл сунгасан сургалтын үйлчилгээ нь сургалтын үйлчилгээний төлөвлөгөөний хүрээнд хандах эрхийн тодорхой хамрах хүрээ, онцлог, үнэтэй байна. Худалдаж авсан сургалтын үйлчилгээгээ хэн нэгэнд шилжүүлэх, түгээх, хуваалцахыг хориглоно.

Бид худалдан авсан сургалтын үйлчилгээний тань төлбөрийг худалдан авалт хийх үед жагсааж харуулна. Төлбөрийг буцаан олгохгүй ба холбогдох хуульд өөрөөр заагаагүй бол хэсэгчлэн ашигласан хугацаанд буцаан олголт хийхгүй.

Сургалтын үйлчилгээг худалдан авахын тулд та төлбөрийн хэрэгслээ оруулах ёстой. Худалдаж авах сургалтын үйлчилгээндээ бүртгүүлж, төлбөр тооцоо хийхдээ төлбөрийн мэдээллээ өгснөөр та бидэнд болон манай санхүүгийн түнш байгууллагуудад тогтоосон төлбөрийн хэрэгслээр тухайн үеийн сургалтын үйлчилгээний төлбөрийг боловсруулах эрхийг олгож буй юм.

Бид өөрсдийн үзэмжээр сургалтын үйлчилгээний төлөвлөгөө эсвэл сургалтын үйлчилгээнийхээ үнийг өөрчлөх эрхтэй. Холбогдох хуульд өөрөөр заагаагүй бол энэ нь үнийн өөрчлөлт эсвэл таны худалдан авсан сургалтын үйлчилгээнд орсон өөрчлөлтийн талаар танд мэдэгдсэний дараа хүчин төгөлдөр болно.

Бид аль ч сургалтын үйлчилгээний төлөвлөгөөнд сургалтын аль нэг тодорхой контент байгаа эсэх, эсвэл наад зах нь ямар хэмжээний сургалтын контент байх ёстой талаар ямар нэг баталгаа өгөхгүй. Бид аливаа сургалтын үйлчилгээний төлөвлөгөөндөө ирээдүйд нэмэлт боломжуудыг санал болгох, өөрсдийн үзэмжээр сургалтын үйлчилгээний төлөвлөгөөг өөрчлөх, цуцлах эрхтэй.

Маргаан шийдвэрлэлт

Softuni.mn нь эрх зүйн нэхэмжлэл гаргалгүйгээр хэрэглэгчидтэйгээ маргааныг шийдвэрлэхийн тулд чадах бүхнээ зориулдаг. Хэрэв бидний хооронд ямар нэгэн асуудал гарвал та болон **Softuni.mn** эхлээд дор дурдсан албан бус маргааныг шийдвэрлэх үйл явцыг ашиглан аль аль талдаа шударга, эрх тэгш байх шийдэлд хүрэхийн тулд хичээнгүйлэн, үнэнч шударгаар ажиллахыг зөвшөөрч байна.

Бие биенийхээ эсрэг нэхэмжлэл гаргахын өмнө та болон **Softuni.mn** энэ хэсэгт тайлбарласан албан бус маргаан шийдвэрлэх үйл явцад оролцох ёстой.

- Овог нэр, шуудангийн хаяг, и-мэйл хаягийг агуулсан богино, бичгэн мэдэгдэл илгээнэ: а) Маргааны мөн чанар, дэлгэрэнгүй, б) түүнийг шийдвэрлэх санал (нэхэмжилж буй мөнгө ба энэ дүнг хэрхэн тооцсон зэргийг оролцуулан).
- Хоёр талын аль нэг нь нэхэмжлэлийн мэдэгдлийг хүлээн аваад түүнийг албан бусаар шийдвэрлэхийг хичээнэ. Талууд нэхэмжлэлийг хүлээн авснаас хойш **60** хоногийн дотор шийдвэрлэж чадаагүй бол Монгол Улсын Иргэний хуулийн дагуу албан ёсны нэхэмжлэл гаргах эрхтэй.

Бидэнтэй холбогдох арга зам

Бидэнтэй холбогдох хамгийн сайн арга бол манай info@mlctraining.mn цахим шуудангаар холбогдох явдал юм. Манай үйлчилгээний талаарх таны асуулт, санаа зовоосон асуудал, санал хүсэлтийг сонсохдоо бид баяртай байх болно.